



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 364

Улаанбаатар хот

Г “Говийн цог” хоршооны хадгаламж, зээлийн Ү
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.4, 13.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Говийн цог” хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Түдгэлзүүлсэн хугацаанд Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллахыг “Говийн цог” хоршоо/Г.Дашдорж/-нд үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар/Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН